

# Э-Сонин

---

27 дахь дугаар

## Мэдээний Тойм



### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ӨГӨӨЖ  
БАНКНЫ ХАДГАЛАМЖААС ӨНДӨР БАЙНА



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД  
Ж.ЭРДЭНЭБАТ ЦАН ЦОХИЖ, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ  
ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЛЭЭ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН  
БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД



ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ  
ЦААСЫГ ТЕНДЕРИЙН БАТАЛГАА  
БОЛГОХ БОЛОМЖТОЙ

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА,  
ТӨЛБӨР ТООЦООНЫ ГОРИМД  
ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО



Д.АНГАР: ХУУЛЬ БАТАЛЖ, ШИНЭ СИСТЕМ  
СУУРИЛУУЛСАН Ч, КОМПАНИЙН САЙН  
ЗАСАГЛАЛЫГ ОРХИГДУУЛСАН

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН  
МЭДЛЭГ ОЛГОХ  
ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ



ТӨГСӨЛТИЙН БАЯР

### ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- ЗГЖУЦаасны 1 дүгээр сарын арилжааны мэдээлэл.
- Засгийн газрын үнэт цаасны хүүгийн хэмжээг арилжааны банкны ижил хугацаат хадгаламжийн хүүтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.
- Монгол Улсын Сангийн сайд Ж.Эрдэнэбат Монголын хөрөнгийн биржийн 4896 дахь удаагийн арилжааг нээн “Цан” цохиж, үйл ажиллагаатай танилцлаа.
- Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн шийдвэрүүд.
- Засгийн газрын үнэт цаасыг тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа болон урьдчилгаа төлбөрийн баталгаа болгох боломжтой байна.
- Үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоог 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн “Т+1” горим буюу Хөрөнгийн бирж дээр арилжаа хийгдсэн өдрөөс хойш дараагийн ажлын өдөрт багтаан гүйцэтгэж байхаар шийдвэрлэлээ.
- Д.Ангар: Хууль баталж, шинэ систем суурилуулсан ч, компанийн сайн засаглалыг орхигдуулсан

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 1-р сарын арилжааны мэдээ

### СУРГАЛТ


“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт-ыг 2015 оны 2 дугаар сарын 23-ны өдөр явуулахаар төлөвлөж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг утас: 11-313747 /116 дугаараас авна уу.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний 389 дугаар тогтоол, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 23-ны өдрийн 169 дугаар тушаалаар 100.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд арилжаалах шийдвэр гарсан. Энэхүү бондыг долоо хоног болгоны Мягмар гарагт арилжаалсан бөгөөд 1-р сард нийт 32.5 тэрбум төгрөгийн бондын арилжааг 4 өдрийн арилжаагаар арилжсан байна.

Өдөр	ЗГҮЦ-ны нэр	Хугацаа /7 хоног/	Зарагдсан тоо хэмжээ /ш/	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн /төгрөг/
2015.01.06	ЗГЭБ-Б-52-283	52	-	16.625%	-
2015.01.13	ЗГЭБ-Б-52-284	12	130,077	14.690%	12,582,348,210.00
2015.01.20	ЗГЭБ-Б-12-285	28	3,293	15.292%	304,309,423.00
2015.01.27	ЗГЭБ-Б-12-286	12	202,750	14.846%	19,605,519,500.00
<b>Нийт зарагдсан ЗГҮЦ</b>			<b>336,120</b>		<b>32,492,177,133.00</b>






## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ӨГӨӨЖ БАНКНЫ ХАДГАЛАМЖААС ӨНДӨР БАЙНА

Монголын хөрөнгийн биржээр Засгийн газрын үнэт цаасыг арилжиж эхэлснээс хойш тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 12 удаа зохион байгуулж нийт 68,606,043,046.00 төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасыг арилжаад байна.

Засгийн газрын үнэт цаасны хүүгийн хэмжээг арилжааны банкны ижил хугацаат /12 долоо хоног буюу 3 сар/ болон /28 долоо хоног буюу 6 сар/ хадгаламжийн хүүтэй тус тус харьцуулахад харьцангуй өндөр байна.

Үнэт цаасыг эзэмшиж байх хугацаанд мөнгө шаардлагатай болсон тохиолдолд уг үнэт цаасны хугацаа дуусахыг хүлээх шаардлагагүйгээр зах зээл дээр эргүүлэн худалдаж, эзэмшсэн хугацааныхаа хүүг авах боломжтой ба хүүгийн орлого нь татвараас бүрэн чөлөөлөгддөгөөрөө онцлогтой юм.



## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

№	Анхдагч зах зээлийн арилжаа явагдсан өдөр	ЗГҮЦ-ны нэр	MIT Арилжааны системийн симбол	Хугацаа /Тхоног/	Хүүгийн хэмжээ	Нэрлэсэн үнэ	Хямдруулсан үнэ	Хүү төлөгдөх хэлбэр	Дуусах хугацаа
1	2014.11.04	ЗГЭБ-Б-12-274	ZGEB-BL-27/01/15-A0001-0	12	15.795	100,000	96,493	хямдруулсан	2015.01.27
2	2014.11.11	ЗГЭБ-Б-52-275	ZGEB-BD-10/11/15-A0002-16.25	52	16.25	100,000	-	Сар бүр	2015.11.10
3	2014.11.18	ЗГЭБ-Б-12-276	ZGEB-BL-10/02/15-A0003-0	12	15.99	100,000	96,451	хямдруулсан	2015.02.10
4	2014.11.25	ЗГЭБ-Б-28-277	ZGEB-BL-09/06/15-A0004-0	28	16.3	100,000	91,952	хямдруулсан	2015.06.09
5	2014.12.02	ЗГЭБ-Б-12-278	ZGEB-BL-24/02/15-A0005-0	12	15.96	100,000	96,457	хямдруулсан	2015.02.24
6	2014.12.09	ЗГЭБ-Б-52-279	ZGEB-BD-08/12/15-A0006-16.625	52	16.625	100,000	-	Сар бүр	2015.12.08
7	2014.12.16	ЗГЭБ-Б-12-280	ZGEB-BL-10/03/15-A0007-0	12	15.731	100,000	96,506	хямдруулсан	2015.03.10
8	2014.12.23	ЗГЭБ-Б-28-281	ZGEB-BL-07/07/15-A0008-0	28	16.436	100,000	91,890	хямдруулсан	2015.07.07
9	2014.12.30	ЗГЭБ-Б-12-282	ZGEB-BL-24/03/15-A0009-0	12	15.653	100,000	96,523	хямдруулсан	2015.03.24
10	2015.01.13	ЗГЭБ-Б-12-284	ZGEB-BL-07/04/15-A0010-0	12	14.690	100,000	96,730	хямдруулсан	2015.04.07
11	2015.01.20	ЗГЭБ-Б-28-285	ZGEB-BL-04/08/15-A0011-0	28	15.292	100,000	92,411	хямдруулсан	2015.08.04



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД Ж.ЭРДЭНЭБАТ ЦАН ЦОХИЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсч хөгжсөний 24 жилийг тохиолдуулан 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Сангийн сайд Ж.Эрдэнэбат Монголын хөрөнгийн биржийн 4896 дахь удаагийн арилжааг нээн “Цан” цохиж, үйл ажиллагаа танилцлаа.

Монголын хөрөнгийн бирж ойн баярынхаа өдрөөр Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг албан ёсоор эхлүүлж байгаа юм. Тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээр зах зээлийн хөрвөх чадвар сайжирч, үнэт цаасны хүртээмж нэмэгдэж, хөрөнгө оруулагчид Засгийн газрын үнэт цаасыг өдөр бүр худалдан авах, төлбөр төлөх хугацаанаас өмнө эргүүлэн худалдах боломж бүрдэх юм.

Ингэснээр Монголын хөрөнгийн зах зээл дээрх суурь хүү /benchmark/ болон өгөөжийн муруй /yield curve/ өрсөлдөөнт бодит горимд тогтох боломж нээгдэж эдийн засгийн чиг хандлагыг бодитоор илэрхийлэх тоон үзүүлэлт шинээр бий болох ач холбогдолтой юм.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД

### ШИЛДЭГ ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖИЛИЙН ХӨЛСИЙГ ХӨНГӨЛЛӨӨ

Монголын хөрөнгийн биржийн Гишүүнчлэлийн журмын 7.2 дахь заалтыг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2015 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 07 тоот тушаалаар 2014 онд хийгдсэн нийт арилжааны үнийн дүнгийн 10-аас дээш хувьтай тэнцэх гүйлгээг дангаар хийсэн “Би Ди Сек ҮЦК” ХК болон “Ти Ди Би капитал ҮЦК” ХХК-ийн 2015 оны гишүүнчлэлийн жилийн хөлсийг 10 хувиар хөнгөллөө.

#### НЭР БҮХИЙ КОМПАНИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ СЭРГЭЭЛЭЭ

1	“Дархан брокер ҮЦК” ХХК	6	“Гүүдсек ҮЦК” ХХК
2	“Санар ҮЦК” ХХК	7	“Асе энд Т ҮЦК” ХХК
3	“Монсек ҮЦК” ХХК	8	“Зэт Жи Би ҮЦК” ХХК
4	“Масдак ҮЦК” ХХК	9	“Ай Трейд ҮЦК” ХХК
5	“Булган брокер ҮЦК” ХХК		

#### “ЭМ ДАБЛЮ ТИ ЭС ҮЦК” ХХК-ИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ СЭРГЭЭЛЭЭ

Монголын Хөрөнгийн Биржийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 201 тоот тушаалаар “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу үүргээ биелүүлээгүйн улмаас нэр бүхий 18 үнэт цаасны компанийн арилжаанд оролцох эрхийг гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэх хүртэл хугацаанд хязгаарласан.

“Эм даблЮ Ти Эс ҮЦК” ХХК гэрээнд заасан үүргээ биелүүлсэн тул “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлийн 83.1, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэх заалтыг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 25 тоот тушаалаар арилжаанд оролцох эрхийг сэргээлээ.

#### “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК НЬ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь байгууллагын хөрөнгийг үр ашигтай удирдах, мөнгөн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд банкны харилцах данс дахь өөрийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасанд байршуулахаар болоод байна.

Засгийн газрын үнэт цаас нь өгөөж өндөр, эрсдэлгүй, хөрвөх чадвар сайтай санхүүгийн хэрэгсэл юм.

Засгийн газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг шуурхай, ил тод нээлттэй байдлаар байгууллагын цахим хуудасны “Шилэн данс”-ны хэсэгт тухай бүр байршуулж байх болно.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСЫГ ТЕНДЕРИЙН БАТАЛГАА БОЛГОХ БОЛОМЖТОЙ



Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Засгийн газрын үнэт цаас тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа болон урьдчилгаа төлбөрийн баталгаа болгох боломжтой юм. Тус хуулийн заалтуудын биелэлтийг хангаж “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл Засгийн газрын үнэт цаасыг тусгаарлан бүртгэх журмыг баталсан байна.




### ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА, ТӨЛБӨР ТООЦООНЫ ГОРИМД ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар 2013, 2014 онуудын үнэт цаасны зах зээлийн арилжааны хэмжээ, хөрвөх чадвар хангалтгүй байгааг хэлэлцээд, Хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТТТХТ” ХХК, МҮЦАЭХ-ны төлөөл бүхий Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх, түүний хөрвөх чадварыг сайжруулах суурь нөхцөлийг бүрдүүлэх үүднээс үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоог 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн “Т+1” горим буюу Хөрөнгийн бирж дээр арилжаа хийгдсэн өдрөөс хойш дараагийн ажлын өдөрт багтаан гүйцэтгэж байхаар шийдвэрлэлээ.

Тогтоолын заалтаар үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны гүйцэтгэлийг баталгаажуулах, төлбөр, тооцооны эрсдэл үүсгэхгүй байх зорилгоор арилжааны банкн дахь үнэт цаас худалдах, худалдан авах харилцагчийн тусгай дансанд үнэт цаасны төлбөрийг 100 хувь урьдчилан байршуулсны дараа захиалгыг Хөрөнгийн биржийн арилжааны системд оруулж байх, брокер, дилерийн компани үнэт цаасны төлбөр гүйцэтгэх нэгээс дээш тооны банкныг сонгох нөхцөлийг хангах, Төлбөрийн баталгааны сан болон барьцаа хөрөнгийн санд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг чөлөөлөхийг холбогдох байгууллагуудад тус тус үүрэг болгов.

Энэхүү тогтоол батлагдсанаар үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадварыг өсгөх, арилжааны хэмжээг нэмэгдүүлэх ач холбогдолтой бөгөөд цаашид төлбөр, тооцооны бие даасан бүтцийг бий болгож, кастодианы үйл ажиллагааг зах зээлд бүрэн нэвтрүүлснээр уг төлбөр тооцооны горимыг Т+3 хүртэл хугацаагаар сунгах боломжтой аж.

## Д.АНГАР: ХУУЛЬ БАТАЛЖ, ШИНЭ СИСТЕМ СУУРИЛУУЛСАН Ч, КОМПАНИЙН САЙН ЗАСАГЛАЛЫГ ОРХИГДУУЛСАН



**-Хөрөнгийн бирж муу менежментээр ажиллаж байгаа учраас эдийн засагт эзлэх байр суурьгүй байна хэмээн судлаач, эдийн засагчид хэлдэг?**

-Хэдийгээр 24 жилийн түүхтэй гэх боловч хөгжөөгүй. Тэгэхээр менежмент муу гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа юм. Тиймээс Хөрөнгийн биржийн удирдлагыг өнгөрсөн хавар Төрийн өмчийн хорооноос Сангийн яам руу шилжүүлсэн. Тухайн үед тус биржийн байдал муу байсан. Бараг л дампуурлын ирмэгт байсан гэдгийг мэргэжилтнүүд хэлдэг юм. Ийм хүнд байдалтай салбарыг удирдаж, зөв голдиролд оруулна гэдэг амаргүй даваа. Хэдийгээр унаж байгааг нь мэдэж байсан ч өмнөх алдааг нь ярихыг хүсээгүй. Харин цааш нь сэргээхийн төлөө эрчимтэй ажиллаж байна.

**-Арилжааг сэргээхийн тулд ямар ажил хийж байна. Арилжаа идэвхжиж байгаа тухай мэргэжилтнүүд ярьж байгаа ч төдийлөн хангалттай биш гэлцэх юм?**

-Ирээдүй бий. Аль ч улсын хувьд хөрөнгийн зах зээл нь эдийн засгийн гол тулгуур байдаг. Тиймээс суурийг нь зөв эхлүүлэх хэрэгтэй. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлбэл маш олон боломж бий болно. Сангийн яам бодлогоор дэмжин хувьцааны зах зээлийг хөгжүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн шинэ бүтээгдэхүүн оруулж ирэх, компанийг нээлттэй болгоход анхаарч ажиллаж байгаа. Үүнд компанийн засаглал маш чухал юм. Энэ мэтчилэн олон ажил төлөвлөсөн байгаа. Тухайлбал, Засгийн газрын үнэт цаасны арилжааг бирж рүү татаж оруулсан нь амжилттай хэрэгжиж байна. Ингэснээр арилжаа огцом сэргэж байгааг хүмүүс харж байгаа болов уу.

**-Хувьцааны арилжаа сайн байснаа гэнэт муудсаны учир юу вэ. Үүнийг олон янзаар л тайлбарлах юм?**

-Хувьцааны зах зээл дууссан гэдгийг хүмүүс хэлдэг. Гэхдээ энэ нь муудаа биш анх гарч ирсэн үүргээ биелүүлсэн. Энэ зах зээл анх төрийн өмчийн 475 аж ахуйн нэгжийг хувьчлах зорилгоор эхлүүлж байсан. Тэгэхээр арилжааны дүн муудсан нь аж ахуйн нэгжүүд хувьчлагдаад дуусч байгаатай холбоотой. Тиймээс шинэ бүтээгдэхүүн оруулж ирэх зайлшгүй шаардлагатай юм. Засгийн газрын үнэт цаасны



арилжааг оруулж ирснээр гүйлгээ сайжирсан. Энэ арилжааг оруулж ирэхээс өмнө Хөрөнгийн биржийг ТҮЦ, гар дээрх наймаатай зүйрлэж байсан. Хатуу боловч гашуун үнэн. Харин одоогоор өдрийн дундаж арилжаа тэрбумаас дээш хэмжээтэй болсон учраас өөрөөр харж эхэлж байна.

**-Арилжаа унасан бас нэг шалтгааныг шинэ сүлжээ оруулж ирсэнтэй холбож тайлбарладаг шүү дээ?**

-Лондонгийн Хөрөнгийн биржтэй хамтарч ажилласнаар арилжаа муудсан гэдэг нь ташаа ойлголт. Харин дэлхийн хэмжээний байгууллагатай нягт хамтарч ажиллаж чадаагүй нь бидний буруу. Асуудлыг зориуд мушгин гуйвуулж, шийдвэр гаргагчдыг буруу ташаа мэдээллээр төөрөгдүүлж ирсэн. Бүр үндэсний аюулгүй байдалд ч сөргөөр нөлөөлнө гэж ярьдаг хүмүүс өнөөдөр хүртэл байгаа нь харамсалтай.

**-Хамгийн гол нь манай улсын аж ахуйн нэгжийн хувьд компанийн сайн засаглал хэрэгжүүлж чадахгүй байгаа нь хөрөнгийн зах зээл хөгжих боломжийг боомилдог. Энэ тал дээр ямар арга хэмжээ авах вэ?**

-Бидний дунд нэг ташаа ойлголт бий. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдаад л гадаад, дотоодын томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагчид орж ирнэ гэж тооцоолсон. Энэ бол маш гэнэн зүйл. Сайн компанийн засаглалгүй бол шууд унана гэдгийг тооцсонгүй. Тиймээс эхлээд хувьцаат компаниудаа нээлттэй ил тод, хариуцлагатай, үр ашигтай болгож компанийн сайн засаглалтай болгохоор ажиллаж байна. Учир нь хөрөнгө оруулалтын томоохон сангуудын дүрэмд нь “Тухайн компани сайн засаглалтай, ил тод, хариуцлагатай байх” гэсэн заалт нэн түрүүнд тавигддаг

юм. Манай улсын аж ахуйн нэгжийн хувьд мэдээлэл байхгүй, тайлан тооцоо нь нууц, ашиг сонирхлын зөрчилтэй гүйлгээ явагддаг нь нууц биш. Тэгэхээр бид гадны хөрөнгө оруулагчдыг татах тухай ярихаас өмнө эхлэлийн цэгээ зөв болгох ёстой.

**-Хөрөнгийн биржийн бүртгэлийн журам шинээр баталсан гэж сонслоо. Өмнөхөөсөө юугаараа ялгаатай вэ?**

-Өмнө нь “А”, “Б” самбар гэж байлаа. Энэ хоёр самбарын “А” хэсэг томоохон компани, “Б”-д нь жижиг, дунд нь ордог байсан юм. Одоо дахин нэг самбар шинээр нээсэн. Уг самбарт компанийн сайн засаглалтай байх ёстой гэдэг шалгуур тавьсан. Харамсалтай нь одоогоор энэ самбарт гарах компани алга байна. Тэгэхээр энэ самбарт орох аж ахуйн нэгжийг бэлтгэх хэрэгтэй болж байгаа юм. Тиймээс ТОП-20 компанийн засаглалыг сайжруулахаар Тунхаг бичигт гарын үсэг зурсан.

**-ҮЦТТХТ-ийг Хөрөнгийн биржид хариуцуулах тухай ярьж байна. Энэ нь хэр зөв шийдэл вэ?**

-Нэг удирдлагатай байсан байгууллагыг 2002 оноос хоёр хэсэг болгосон нь маш буруу шийдвэр байсан. Энэ алдаагаа засч байна гэж харж байгаа. Учир нь буруу шийдвэрийн үрээр ажлын харилцан уялдаагүй болсон юм. 2011 онд Лондонгийн Хөрөнгийн биржтэй хамтын ажиллагааны хүрээнд хийсэн шинэчлэлийн бүтэлгүйтэл үүнтэй холбоотой. Гэтэл ажлын уялдаагүй байснаас гарсан муу үр дагавараа тус биржид тохих гэж оролдож байна. Хэрэв ингэвэл бид өөрсдөө дэлхийд шившиг болно. Тэгэхээр бид алдаагаа засах ёстой. Тиймээс ч Засгийн газар хоёр байгууллагыг эргүүлэн нэгтгэх шийдвэр гаргасан гэж ойлгож байна. Энэ хоёр байгууллага нэгдсэнээр үйл ажиллагаа цэгцрэн арилжаа нэмэгдэнэ гэж харж байгаа.

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД “ИТГЭМЖЛЭГДСЭН ДИЛЕР”-ИЙН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛНЭ

Хөрөнгийн биржийн өдөр тутмын арилжааг идэвхжүүлж үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулахад мэргэжлийн дилерийн үйл ажиллагаа чухал үүрэгтэй. Хэдийгээр Монголын Хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниуд нь брокер болон дилерийн давхар эрхтэй байдаг боловч ихэнх үйл ажиллагаа нь зөвхөн брокерийн буюу харилцагчийн даалгавраар үнэт цаас худалдах, худалдан авах захиалгыг биелүүлэх чиглэлээр хязгаарлагддаг юм.

Үүнээс шалтгаалж хөрөнгө оруулагч хүссэн үнэт цаасаа худалдан авч чадахгүй эсвэл өөрийн эзэмшлийн үнэт цаасаа хүссэн цагтаа зарж чадахгүйд хүрдэг бөгөөд энэ нь нийт зах зээлийн хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж ирсэн. Тиймээс Монголын Хөрөнгийн биржээс 2015 оны 2 дугаар 16-наас эхлэн олон улсын хөрөнгийн зах зээлийн стандарт дэд бүтэц болох “Market Makers” буюу “Итгэмжлэгдсэн дилер”-ийн тогтолцоог нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Ингэснээр “Итгэмжлэгдсэн дилер” үнэт цаасны компаниуд Монголын Хөрөнгийн биржийн арилжааны өдөр бүр Засгийн газрын үнэт цаас худалдах, худалдан авах үнийн саналыг давхар гаргах юм. Ингэснээр тухайн үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээл дээрх хөрвөх чадвар нэмэгдэж хөрөнгө оруулагч хүссэн өдрөө үнэт цаас худалдан авах эсвэл түүнийгээ эргүүлэн зарах боломжтой болох бөгөөд энэ нь улмаар Монголын үнэт цаасны зах зээлийн арилжааны идэвх, хөрөнгө оруулагч нарын оролцоог нэмэгдүүлнэ гэж тооцоолж байна.

Ирээдүйд “Итгэмжлэгдсэн дилер”-ийн тогтолцоог компанийн хувьцаа, үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд нэвтрүүлэх боломжтой.

## ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яамны харьяа “Шинэ эрин” лаборатори сургуулийн 6а ангийн сурагчид мөн “Хобби” дунд сургуулийн 12 А ангийн сурагчид Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагаатай танилцах, салбарын талаар ерөнхий мэдлэг, мэдээлэл олж авах зорилгоор 2015 оны 1 дүгээр сарын 08, 28-ны өдрүүдэд 10-11 цагт Монголын хөрөнгийн биржид зочилж, биржийн үйл ажиллагаатай танилцаж, ах эгч нараасаа сонирхсон асуултыг асууж, хариултыг авлаа.





ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ  
ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ

ТӨГСӨЛТИЙН БАЯР



“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2014 оны 12 дүгээр сарын 15-наас 23-ны хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Энэ удаагийн сургалтад амжилттай суралцсан 25 суралцагч сертификат гардан авлаа.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2015 оны 2 дугаар сарын сүүлээр 23-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.


*Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье*



### Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	5,728,726
Нийт үнийн дүн	33,519,347,928
Хэлцлийн тоо	930
Арилжигдсан үнэт цаасны тоо	66
Зах зээлийн үнэлгээ	1,378,363,060,774

### ТОП 20 ИНДЕКС



### ТОП-20 индекс

Хаалт	14,290.63
Өмнөх сарын хаалт	14,854.24
Өөрчлөлт /нэгж/	-563.61
Өөрчлөлт /%/	-3.79
52 долоо хоног дээд	17,160.49
доод	14,389.27

### Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:					Үнийн дүнгээр:				
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн
1	HGN	ХӨХ ГАН	4,399,729	502,107,047	1	HGN	ХӨХ ГАН	4,399,729	502,107,047
2	MRX	МЕРЕКС	603,106	58,122,840	2	APU	АПУ	16,994	62,733,008
3	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	77,610	43,406,889	3	MRX	МЕРЕКС	603,106	58,122,840
4	RMC	РЕМИКОН	62,846	5,741,283	4	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮ	77,610	43,406,889
5	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	61,464	9,794,090	5	BHR	БИНСЭ ХК	48,485	38,283,150

### Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	UBH	УЛААНБААТАР ХИВС	12,400	14,800	2,400	19.35
2	GTL	ГУТАЛ	9,500	11,000	1,500	15.79
3	UYN	МОНГОЛ САВХИ	950	1,100	150	15.79
4	SOR	СОР	1,800	2,070	270	15.00
5	TAV	ТАВ	30,500	35,000	4,500	14.75

### Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	DLG	МОНГОЛ МАХ ЭКСПО	3,780	2,423	-1,357	-35.90
2	SUU	СҮҮ	120,000	88,800	-31,200	-26.00
3	HNC	БИШРЭЛТ ИНДАСТРИ	2,470	1,850	-620	-25.10
4	SHV	ШИВЭЭ ОВОО	5,000	3,900	-1,100	-22.00
5	GTJ	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭ	3,600	3,000	-600	-16.67

### Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	Хүүгийн хэмжээ % /жил/	Нэрлэсэн үнэ	Хямдруулсан үнэ
1	ЗГЭБ-Б-12-284	130,077	12,582,348,210	14.690	100,000	96,730
2	ЗГЭБ-Б-28-285	3,293	304,309,423	15.292	100,000	92,411
3	ЗГЭБ-Б-12-286	202,750	19,605,519,500	14.840	100,000	96,698

### Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	Хүүгийн хэмжээ % /жил/	Нэрлэсэн үнэ	Хямдруулсан үнэ
1	ZGEB-BD-10/11/15-A0002-16.25	550	55,000,000	16.25	100,000	-
2	ZGEB-BL-10/02/15-A0003-0	123	12,261,870	15.99	100,000	96,451

### Анхдагч зах зээлийн арилжаа: /хувьцаа/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	Нэгж үнэ
1	BDS	БИДИСЕК	189	405,594	2,146